# 2019

# ЖИЛИЙН ТАЙЛАН

MONGOLIAN
STOCK EXCHANGE

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

# АГУУЛГА


| | |
|---|---|
| Гүйцэтгэх захирлын мэндчилгээ | 1 |
| Бидний тухай | 2 |
| 2019 оны санхүүгийн гол үзүүлэлтүүд | 7 |
| Алсын хараа, стратеги, гүйцэтгэл | 8 |
| Оны онцлох үйл явдлууд | 12 |
| Үйл ажиллагааны болон санхүүгийн тойм | 21 |
| Компанийн засаглал | 26 |
| Хөрөнгийн зах зээлийн тойм | 34 |
| Хараат бус аудитын дүгнэлт | 47 |
| Санхүүгийн тайлан | 50 |

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсанаас хойш эдүгээ 29 жилийг туулан өнгөрүүлжээ. Өнгөрсөн хугацаанд Монголын хөрөнгийн зах зээлийн техник технологи, хууль эрх зүйн орчин олон улсын жишгийн дагуу шинэчлэгдэж, манай зах зээл хөгжлийн шинэ шатанд гарсан билээ.

Сүүлийн жилүүдэд манай хөрөнгийн зах зээлд хувьцаа бондын арилжаа идэвхжиж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах зэрэг олон үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаагийн зэрэгцээ онцлог шинэ үйл явдлуудаар өрнүүн байна. Тухайлбал, 2017 онд МХБ түүхэндээ анх удаа 859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийж, ТОП-20 индекс 68.9 хувиар, зах зээлийн үнэлгээ 67.4 хувиар тус тус өссөн, 2018 онд хамгийн олон компани үнэт цаасаа бүртгүүлсний зэрэгцээ үнэт цаасны анхны давхар бүртгэл, даатгалын компанийн үнэт цаас бүртгэгдсэн онцлог үйл явдал тохиосон бол 2019 онд үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хамгийн өндөр түвшинд хүрсэн юм.

МХБ нь зах зээлийн энэхүү таатай орчин нөхцөлд тулгуурлан хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор МХБ дээр арилжигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх, зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд зах зээлийн зохицуулагч болон мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна.

Монголын хөрөнгийн зах зээлд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, өмнөх зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхэд бидний хамтын ажиллагаа бодит үр дүнд хүрнэ гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд хамтран ажилладаг зах зээлийн оролцогчид, үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчид та бүхэнд өндөр амжилт хүсье.

Хөрөнгийн зах зээл цаашид улам хөгжин дэвшиж, хөгжлийн гарц байх болтугай!

Х. АЛТАЙ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

# БИДНИЙ ТУХАЙ

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн түүхэн үе шатанд улсын эдийн засгийн нийт бүтцийг өөрчлөх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, эдийн засагт хувийн секторыг дэмжин хөгжүүлэх, улмаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг биелүүлэхийн тулд өмч хувьчлалыг аль болох богино хугацаанд өргөн хүрээтэйгээр явуулан цаашид эдийн засаг дахь хөрөнгийн урсгалыг хамгийн үр ашигтай хэлбэрээр зохицуулах зорилгоор Монголын хөрөнгийн биржийг /МХБ/ үүсгэн байгуулсан. Энэхүү түүхэн үед МХБ-ээр 475 улсын үйлдвэрийн газрын хувьцааг цэнхэр, ягаан тасалбараар 1.2 сая иргэнд эзэмшүүлж хувьчилснаар Монгол Улсад орчин үеийн зах зээлийн эдийн засгийн үндэс суурь тавигдаж байсан.

МХБ нь энэхүү түүхэн үүргээ амжилттай гүйцэтгэхийн сацуу өнөөг хүртэл 40 гаруй аж ахуйн нэгжид 187.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхэд зуучлан, нийт 3.3 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа зохион байгуулаад байна.

| 1995 он | 2019 он | |
|---|---|---|
| **₮11.6 тэрбум** | **₮2,690.3 тэрбум** | Зах зээлийн үнэлгээ |
| **87.35** | **19,621.86** | ТОП-20 индекс |
| **475** | **198** | Бүртгэлтэй компанийн тоо |
| **₮3.2 сая** | **₮570 сая** | Өдрийн дундаж арилжаа |
| **₮43.4 сая** | **₮1.5 тэрбум** | Жилийн нийт орлого |

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу МХБ нь олон улсад нэр хүнд бүхий Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник, технологи, дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлсэн билээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 онд шинэчлэн найруулахад МХБ-ийн зүгээс чухал үүрэгтэйгээр оролцож, үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсний үр дүнд гадаад улсын компанийн үнэт цаасны давхар бүртгэл, хадгаламжийн бичиг, төлбөр тооцооны дараа төлбөрт систем, үнэт цаасны номиналь болон бенефициар өмчлөл, кастодианы үйлчилгээ зэрэг олон шинэ концепциуд зах зээлд шинээр нэвтэрсэн юм. Ингэснээр 2018 онд гадаад улсын компанийн үнэт цаасыг анх удаа МХБ дээр давхар бүртгэж арилжаалсан, арилжааны үнийн дүн хамгийн дээд хэмжээндээ хүрсэн, 2019 онд анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн дээд амжилтаа тогтоосон зэргээр хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд урьд өмнө байгаагүйгээр идэвхжиж, чамлахааргүй их амжилтанд хүрч байна.

Түүнчлэн, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг цоо шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт T+2 горимд нэвтрүүлэх чиглэлд зах зээлийн бусад оролцогчдын хамт бид ажиллаж байна.



1991 он



2019 он

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




## ГАЗРУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

**Захиргаа, санхүүгийн газар** нь компанийн дотоод зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж ажиллах ба чиг үүргээрээ Захиргааны алба, Санхүүгийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

**Үйл ажиллагааны газар** нь арилжааны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах, хөрөнгийн биржийн мэдээллийн технологийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих үндсэн чиг үүрэгтэйгээр Зах зээлийн хөгжлийн алба, Арилжааны алба, Мэдээллийн технологийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

**Хяналт, зохицуулалтын газар** нь бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаас гаргагч байгууллагууд, гишүүн үнэт цаасны компани, арилжааны хяналт, хөрөнгийн зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх чиг үүрэгтэйгээр Хяналт шинжилгээний алба, Бүртгэлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

# УДИРДЛАГЫН БАГ



Гүйцэтгэх захирал
**Х. Алтай**

*Хуульч*
*Бизнесийн удирдлагын магистр*

МХБ-ийн гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлагын талаар Компанийн дүрэмд тодорхой заасан байдаг. Гүйцэтгэх захирал нь МХБ-ийн өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-өөс баталсан үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

**Удирдлагын багийн гишүүд**



Захиргаа, санхүүгийн газрын захирал
**Н. Дөл-Эрдэнэ**

*Санхүүч-эдийн засагч*
*Бизнесийн удирдлагын магистр*
*Олон улсын бизнесийн удирдлагын докторант*

Хяналт, зохицуулалтын газрын захирал
**А. Мөнхбаясгалан**

*Эдийн засагч*
*Төрийн удирдлагын магистр*





Үйл ажиллагааны газрын захирал
**Д. Энхзул**

*Санхүүч*
*Санхүүгийн магистр*
*Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч (CFA)*
*Олон улсын мэргэшсэн төслийн менежер (PMP)*

# ХҮНИЙ НӨӨЦ

МХБ-ийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав.

Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2019 оны эцэст нийт 50 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба урт хугацааны чөлөөтэй 8 ажилтан байна.

**50**
Нийт ажилтан

**27**
Нийт эмэгтэй ажилтан

**23**
Нийт эрэгтэй ажилтан

**27**
Үндсэн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

**19**
Захиргаа, аж ахуйн ажилтан

**32**
Дундаж нас

**8 жил**
Ажилласан дундаж хугацаа

**12**
Удаагийн сургалт

**45**
Дээд боловсрол

**Үүнээс:**

**19**
Магистр

**26**
Бакалавр

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧДЫН ИНСТИТУТ

**2**
Мэргэшсэн нягтлан бодогч

CFA® PROGRAM

**1** Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч

**3** Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч цол горилогч

CISCO CERTIFIED CCNA

**1** Олон улсын мэргэшсэн компьютерийн сүлжээний инженер

# СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт орлого, сая ₮




Нийт зардал, сая ₮




Арилжааны шимтгэл, сая ₮




MIT системийн ашиглалт, үйлчилгээний төлбөр, сая ₮




Хураамж, үйлчилгээний хөлс, сая ₮




Цалингийн зардал, сая ₮




Төсөвт төлсөн татвар, шимтгэл, сая ₮




Цэвэр ашиг, сая ₮



# АЛСЫН ХАРАА, СТРАТЕГИ, ГҮЙЦЭТГЭЛ

## Алсын хараа

Ил тод, нээлттэй зах зээлийн тогтолцоог бэхжүүлж, санхүүгийн төрөлжсөн хэрэгслүүд бүхий хөрвөх чадвар сайтай, бүс нутагт өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг бий болгоно

## Стратегиийн зорилго, зорилтууд




Хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх



Бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэ цэнийг нэмэгдүүлэх



Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд бусад мэргэжлийн оролцогчидтой хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх



Хөрөнгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг дэмжих



Дотоод үйл ажиллагааг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2019 ОНД

## Стратегийн төлөвлөгөөний биелэлт




Хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

- “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг боловсруулан Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулснаар шинэ бүтээгдэхүүн зах зээлд бодитойгоор нэвтрэх боломж бүрдлээ.
- 2019 онд нийт 4 компани үнэт цаасаа олон нийтэд санал болгох замаар нээлттэй хувьцаат компани болж 42.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн нь сүүлийн 3 жилийн дунджаас 226.3%-иар өссөн үзүүлэлт боллоо.
- Хувьцааны өдрийн дундаж арилжааны хэмжээ 2016-2018 онуудын дунджаас 19%-иар нэмэгдэж 531.9 сая төгрөгт хүрэв.
- Стратегийн орд газрыг эзэмшигч зарим компаниудтай олон уулзалтууд хийж, үнэт цаас бүртгүүлэх боломж, давуу тал, ач холбогдлын тухай танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудад үнэт цаас давхар бүртгүүлэх тухай семинар зохион байгуулав.



Бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэ цэнийг нэмэгдүүлэх

- Мэдээллийн ил тод байдал, компанийн засаглалыг сайжруулах зорилгоор “Үнэт цаас гаргагчдын тогтмол биелүүлэх журам”-ын төсөл боловсруулав.
- Мэдээллийн шуурхай, ил тод байдал, хувьцаат компанийн хариуцлага ба бүртгэлтэй компаниудын үүргийн хэрэгжилтийн гүйцэтгэлийг 80%-д хүргэх зорилт тавьж ажилласан бөгөөд гүйцэтгэл 2019 онд өмнөх оны үзүүлэлтээс 12%-иар өсч 67%-д хүрэв.




- Бүртгэлтэй үнэт цаасны чанарыг сайжруулах зорилгоор бүртгэлийн шалгуур, шаардлага хангахгүй байгаа нийт 21 хувьцаат компанийг бүртгэлээс хассан бөгөөд үүний үр дүнд нийт бүртгэлтэй компаниудад эзлэх чанаргүй компанийн тоо 13.2%-иар буурсан.

- Бүртгэлтэй компаниудыг нэмж хувьцаа гаргах, хувьцаагаа хуваах, хоорондоо нэгдэж нийлэхийг дэмжиж, зах зээлд сурталчлан, дотоодод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд болон гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудад таниулж 30 гаруй удаагийн танилцуулга хийсэн. (Энэ хүрээнд “Монгол даатгал” ХХК "Хорго хайрхан" ХК-д нэгдсэн бол “Мандал даатгал” ХК, “Баян-Алдар” ХК-иуд хувьцаагаа хуваасан.)
- Хөрвөх чадвар сул зарим үнэт цаасны арилжааг идэвхжүүлж, хувьцааг бодит үнэлгээнд хүргэх талаар санал боловсруулж, СЗХ-нд хүргүүлэв.
- Бүртгэлтэй компаниудын мэдээллийн ил тод байдал болон компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 21 компанийн 2019 оны хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.

---



Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд бусад мэргэжлийн оролцогчидтой хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх

- Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоонд Төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчимд суурилсан T+2 горимыг нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, 12 дугаар сард системийн туршилтыг эхлүүлсэн.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг шинэчлэх, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг сайжруулах ажлын хэсэгт орж ажилласан.
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан саналыг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн.
- Дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хувийн тэтгэврийн санг бий болгох замаар тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх тухай санал боловсруулж, энэ тухай олон нийт болон холбогдох байгууллагуудад чиглэсэн сурталчилгааг тогтмол зохион байгууллаа.

---



Хөрөнгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг дэмжих

- Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хамтын хаалттай сангийн нэгж эрхийг бүртгэх журам”-ыг батлуулж, “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх журам”-ыг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- 2019 оны эхэнд МХБ-ийн арилжаанд оролцож байгаа хөрөнгө оруулагчдын (давтагдаагүй тоогоор) 32.5% -нь онлайнаар арилжаанд оролцож байсан бол 2019 оны эцсийн байдлаар нийт хөрөнгө оруулагчдын 49% онлайнаар арилжаанд орсон үзүүлэлттэй байна.
- Үнэт цаасны арилжааны хяналтыг сайжруулан сэжиг бүхий 899 хэлцэлд шалгалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 41.82%-иар буурсан.
- Хөрөнгийн зах зээлд олон улсын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын мэдээллийн агентлагуудтай “Мэдээлэл нийлүүлэх гэрээ”-г байгуулан зах зээлийн мэдээ, мэдээллийг бодит цагийн горимоор дамжуулан ажиллаж байна.

- 2019 оны 6 сард БНХАУ-ын хөрөнгө оруулалтын сангуудад Монголын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулах боломжийг танилцуулсан.
- 2019 оны 10 сард Шанхай & Шенженийн хөрөнгийн биржийн төлөөлөлтэй уулзаж, хамтран ажиллахаар болов.
- “Эрдэнэс тавах толгой” ХХК-тай хамтран нийт 12 аймгийн төв болон 30 сумдад хөрөнгийн зах зээлийн нээлттэй өдөрлөг болон сургалт зохион байгуулж, 15,000 гаруй иргэдийг хамрууллаа.

---



Дотоод үйл ажиллагааг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх

- Нийт боловсон хүчин, болон зарим мэргэжилтнүүдийг Зөрчлийн тухай хуулийн сургалт, Хөрөнгийн үнэлгээчин бэлтгэх анхан шатны сургалт, Компанийн засаглалын гэрчилгээ олгох, Хувь хүний хөгжил, Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй, Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажилтныг мэргэшүүлэх, Нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг, болон Үнэт цаасны зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, сунгах, аттестатчилах сургалтуудад хамруулав.
- Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаагаар дараах сургалт болон мэргэжлийн зэрэг цол авах шалгалтуудад мэргэжилтнүүдээ хамруулсан:

| | | | |
|---|---|---|---|
| CFA Institute | 4 мэргэжилтэн | Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч | |
| JICA | 1 мэргэжилтэн | Хөрөнгийн биржийн хөгжил | Япон улсад |
| | 2 мэргэжилтэн | Хөрөнгө оруулалтын сан & Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт | Энэтхэг улсад |

- Ур чадвартай ажилтныг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор зах зээлд өрсөлдөхүйц, ажлын бүтээмж, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгохоор ажилласан бөгөөд энэ хүрээнд Мэдээллийн технологийн албаны мэргэжилтнүүдийн цалин хөлсийг нэмэгдүүлэн албаны тогтвортой байдлыг хангахад анхаарч ажиллав.
- Иргэд, ажилтнаас гаргасан нийт 563 өргөдөл, гомдол, хүсэлтийг цаг хугацаанд нь шийдвэрлэлээ.

# ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ БАТЛАМЖЛАГДЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 537 тоот тушаалаар батламжиллаа.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд олон шинэ үнэт цаас амжилттай гарч, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхжихийн хирээр зах зээлийн хөрвөх чадварыг хангах, тогтвортой байдлыг бий болгох асуудал тулгамдаж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа билээ.

Энэхүү журмын дагуу олон улсын биржүүдэд түгээмэл арилжигддаг бүтээгдэхүүн манай зах зээлд цоо шинээр нэвтэрч, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сангууд нэгж эрхээ Биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжих ба хөрөнгө оруулагчид эрсдлээ тараан байршуулж, багц хувьцаанд хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулалтын оновчтой удирдлагаар хангагдах боломж бий болж байна.



Олон улсын практикаас харахад мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлснээр үнэт цаасны үнэ ханш харьцангуй бодит түвшинд, хэлбэлзэл багатайгаар тогтох, арилжааны хэмжээ нэмэгдэхээс гадна жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад зэрэг нөлөө үзүүлдэг байна. Энэхүү журмыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд зах зээлийн мэргэжлийн оролцогчид болох хөрөнгө оруулалтын менежментийн болон үнэт цаасны компаниудад зориулсан танилцуулга, сургалтыг зохион байгууллаа.

## "ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ" БОЛОВСРУУЛЛАА

Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, оролцогчдыг нэмэгдүүлэх замаар зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулахад анхааран ажиллаж байгаа бөгөөд 2020 онд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын төслийг холбогдох хууль, тогтоомжинд нийцүүлэн боловсруулаа.

Тус журам батлагдсанаар санхүүгийн зах зээлийн оролцогч байгууллагууд хөрөнгийн багцаа биржид бүртгүүлж, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээр нэг талаас, санхүүгийн зах зээлийн хөрвөх чадварын эрсдлийг бууруулах, эрсдлийг тараан байршуулах, санхүүжилтийн зардлыг бууруулах замаар нийт зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөгөө талаас хөрөнгө оруулагчид хадгаламжаас өөр тогтвортой орлого олох хөрөнгө оруулалтын сонголт бий болох зэрэг олон талын давуу тал, ач холбогдол бий болох юм.

# 4 КОМПАНИ ҮНЭТ ЦААС ГАРГАН НЭЭЛТТЭЙ КОМПАНИ БОЛЛОО

| | | Хөрөнгө оруулагчдад санал болгосон хувьцааны хувь, тоо | Хөрөнгө оруулагчдын худалдан авахаар захиалсан хувьцааны тоо & ₮ | Захиалга ирүүлсэн хөрөнгө оруулагчдын тоо |
|---|---|---|---|---|
| ARD КРЕДИТ ББСБ<br>Санхүүгийн шинэлэг үйлчилгээг орчин үеийн технологид тулгуурлан хүргэгч, салбарын тэргүүлэгчдийн нэг | | 25% | | |
| | Олон нийт: | 35,000,000ш | 7,318,438,999₮<br>3 дахин давсан | 1,763 |
| | Стратегийн хөрөнгө оруулагч: | 35,000,000ш | 2,450,000,000₮<br>100% биелсэн | 8 |
| InvesCore САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА<br>Салбартаа шинэлэг, шуурхай үйлчилгээ, дэвшилтэт технологийг нэвтрүүлэгч, харилцагчдынхаа санхүүгийн хариуцлагатай дэмжигч | | 15% | | |
| | Олон нийт: | 1,613,878ш | 2,899,735,069₮<br>15.9%-иар давсан | 336 |
| | Стратегийн хөрөнгө оруулагч: | 9,145,310ш | 16,004,292,500₮<br>6.1%-иар давсан | 14 |
| МОНОС ХҮНС<br>Эрүүл мэндийн салбарын анхны IPO | | 30%<br>122,655,128ш | 87,982,368ш<br>21.7%-иар давсан | 3,976 |
| ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧ ТҮМЭН ШУВУУТ ХК<br>Монголын өндөг үйлдвэрлэлийн салбарын 53%-ийг дангаар гүйцэтгэж буй салбартаа тэргүүлэгч | | 25%<br>50,000,000ш | 54,575,195ш<br>9.1%-иар давсан | 2,991 |

## “АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

СЗХ-ны 2019 оны 5 сарын 8-ны өдрийн 102 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Жинст Увс” ХК (MSE:JIV)-д “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай хувьцаат компанийг нэгтгэхийг зөвшөөрсний дагуу тус нэгдсэн компани болох “Ард Санхүүгийн нэгдэл” ХК-ийн үнэт цаас 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн AARD симболтойгоор арилжигдаж эхэллээ.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК нь "Жинст Увс" ХК-тай ийнхүү нэгдсэнээр урвуу нэгдэл (reverse takeover) буюу хаалттай компани нээлттэй компанид нэгтгэгдэх үйл явц амжилттай хэрэгжиж, Монголын хөрөнгийн зах зээлд нэгэн шинэлэг үйл явдал боллоо.

Тус нэгдлийн бүрэлдэхүүнд “Ард Даатгал” ХК, “Ард Кредит ББСБ” ХК, “Ард Секюритиз ҮЦК” ХХК, “Ард Лайф” ХХК, “Ард Актив” ХХК, “Ард Менежмент” ХХК, “Ард Бит” ХХК, “Тэнгэр Систем” ХХК, “Монгол Шуудан” ХК, “ГөүПэй” ХХК, “Номын Хишиг” ХХК, “Крипто Үндэстэн” ХХК, "Дижитал Эксчэнж Монголиа" ХХК болон "ЭмИСи Партнерс" ХХК зэрэг компаниуд багтдаг бөгөөд өөрийн охин болон хараат компаниудаар дамжуулан Монголын хөрөнгийн зах зээлд идэвхтэй оролцдог билээ. Тухайлбал, тус нэгдэл нь 2016 онд "Монгол шуудан" ХК-ийн хувьчлалыг амжилттай хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байсны зэрэгцээ "Ард даатгал" ХК болон "Ард кредит ББСБ" ХК нь МХБ-д үнэт цаасаа шинээр бүртгүүлж, олон нийтээс амжилттай хөрөнгө татан төвлөрүүлсэн.



## "НЭГ ЗОРИЛГО-НЭГДСЭН ШИЙДЭЛ" ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Арилжааны төлбөр тооцоо ХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг хөрөнгийн зах зээлийн зохицуулагч болон дэд бүтцийн байгууллагууд хамтран “Нэг зорилго - Нэгдсэн шийдэл” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа.

“Нэг зорилго-Нэгдсэн шийдэл 2019” хэлэлцүүлэгт оролцогчид “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, чиглэл”, “Хөрөнгийн зах зээлийг дэмжих татварын орчинг бий болгох нь", “Бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлт болон чанарыг сайжруулах нь”, “Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих нь”, “Хөрөнгийн зах зээлийн өртөг зардлыг бууруулах нь” сэдвүүдийн хүрээнд илтгэл тавьж, санал солилцов.

Хэлэлцүүлгээр Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид, үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчдад тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжлийн чиг хандлага, гарц шийдлийг хамтран хэлэлцэж, холбогдох зөвлөмжийг гаргаж цаашид нэг зорилготойгоор хамтран ажиллахаар боллоо.





## ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ЗОЧИЛЛОО

Лондонгийн хөрөнгийн биржийн Гүйцэтгэх Захирал Ноён Нихил Рати, Лондонгийн хөрөнгийн бирж группийн Европын бүсийн Анхдагч зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан захирал Хатагтай Аюуна Нечаева, ИБУИНВУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ноён Филипп Малоне нар Монголын хөрөнгийн биржид зочилж, 5916 дахь удаагийн арилжааг нээж цан цохилоо.




Энэхүү арга хэмжээний дараа МХБ-ийн удирдлагуудтай уулзалт хийсэн бөгөөд уулзалтын үеэр МХБ болон ЛХБ-ийн хамтын ажиллагаа сүүлийн 8 жилийн хугацаанд үр дүнтэй хэрэгжиж, томоохон ахиц дэвшлүүд гарсныг дурдаад, цаашид Лондонгийн болон Монголын хөрөнгийн зах зээлд давхар бүртгэл хийх замаар шинэ бүтээгдэхүүнүүд бий болгох, зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах, Монголын хөрөнгийн зах зээлийг Лондон дахь хөрөнгө оруулагчдад сурталчлах, дотоодын мэргэжлийн боловсон хүчний чадвахийг бэхжүүлэх зэрэг олон чиглэлээр үргэлжлүүлэн хамтран ажиллах сонирхолтой байгаагаа хоёр талаас илэрхийллээ.

Монголын хөрөнгийн бирж нь Лондонгийн хөрөнгийн биржтэй 2011 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр Ажлын мастер гэрээ байгуулж, хамтын ажиллагаагаа эхлүүлж байсан бөгөөд тус гэрээний хүрээнд хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орч-ныг сайжруулах, шинэ техник, технологи суурилуулах, МХБ-ийн зохистой бүтэц, засаглалыг бий болгох, дотоодын мэргэжилтнүүдийг чадавхижуулах гэсэн үндсэн зорилтуудын хүрээнд шат дараалсан үйл ажиллагаануудыг амжилттай хэрэгжүүлж, дорвитой үр дүнд хүрсэн билээ.

Цаашид, зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дотоодын зах зээлийг олон улсын хөрөнгө оруулагчдад сурталчлах, өмч хувьчлалыг хэрэгжүүлэх, дотоодын компаниудад хөрөнгө босгоход туслалцаа үзүүлэх, зах зээлийн чадавхийг бэхжүүлэхэд Лондонгийн хөрөнгийн биржийн байр суурь, оролцоо чухал болохыг талууд онцлон тэмдэглэв.

## ЭНЭТХЭГ УЛСЫН ЭЛЧИН САЙД АРИЛЖАА НЭЭЖ ЦАН ЦОХИЛОО

Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Ноён М.П Сингх Монголын хөрөнгийн биржид зочилж, 6,004 дэх удаагийн үнэт цаасны арилжааг нээж цан цохилоо.



Энэхүү ёслолын арга хэмжээний дараа болсон хөрөнгийн зах зээлийн талаарх танилцуулга уулзалтын үеэр Монголын хөрөнгийн зах зээлд Энэтхэг улсын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, Энэтхэг улсын зүгээс хэрэгжүүлж буй төслүүдийг хөрөнгийн зах зээлийн оролцоотойгоор хэрэгжүүлэх боломж гэх зэрэг олон асуудлаар санал бодлоо солилцож, цаашид идэвхтэй хамтран ажиллах сонирхолтой байгаагаа талууд илэрхийллээ.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГИЙГ 7 АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МХБ нь орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Арилжааны төлбөр тооцооны төв, үнэт цаасны компаниуд болон "Эрдэнэс таван толгой" ХК-тай хамтран Өвөрхангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Завхан, Архангай, Хөвсгөл аймгуудад "Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг" арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



Өдөрлөгийн үеэр хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулснаас гадна "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэргээр нийт 15,000 гаруй иргэдэд нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ.

## АНУ-С МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙД МАЙКЛ С. КЛЕЧЕСКИ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ЗОЧИЛЛОО

Элчин сайд Ноён Майкл С. Клечески болон тус Элчин сайдын яамны холбогдох төлөөлөгчид Монголын хөрөнгийн биржид зочилж, 6,017 дахь удаагийн үнэт цаасны арилжааг нээж цан цохилоо.

Ёслолын үйл ажиллагааны үеэр Элчин сайд Майкл С. Клечески "Аливаа улсын эдийн засагт хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэх үүрэг асар чухал билээ. Монгол Улсын хөрөнгийн зах зээл идэвхжиж байгаа энэ цаг үед нэгэнт шинэчлэгдэн сайжирсан хууль эрх зүйн орчин, хуримтлуулсан туршлагадаа суурилан төрийн өмч хувьчлалыг МХБ-ээр дамжуулан хэрэгжүүлэх, тэр дундаа МХБ болон тооцооны байгууллагыг хувьчлах нь манай улсын төдийгүй олон улсын хөрөнгө оруулагчдыг татаж, Монголын хөрөнгийн зах зээл олон улсын зах зээл болоход чухал алхам болох юм" хэмээн онцлон тэмдэглээд, МХБ-ийн хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурав.



## БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУД 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА НЭЭЛТТЭЙ ТАНИЛЦУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдал, үүргийн хэрэгжилт, компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангуулах зорилгоор МХБ-ийн бүртгэлтэй компаниудын хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй илтгэл хэлбэрээр танилцуулах ажлыг 2019 оны 8 дугаар сарын 7-20-ны өдрүүдэд 4 дэх жилдээ уламжлал болгон зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК, “Таван толгой” ХК, “Мик Холдинг” ХК, “Говь” ХК, “Дархан нэхий” ХК, “АПУ” ХК, “Монгол шуудан” ХК, "Ард Даатгал" ХК, "Талх чихэр" ХК, "Мандал Даатгал" ХК, "ЛэндМН ББСБ" ХК, 2-р ангилалд бүртгэлтэй “Монгол Базальт” ХК, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК, "Ард Кредит ББСБ" ХК, "Түмэн шувуут" ХК, 3-р ангилалд бүртгэлтэй "Инвескор ББСБ" ХК нийт 16 компаниуд оролцож, олон нийтэд үйл ажиллагаагаа танилцууллаа.

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АЖИЛТНУУД ХОТЫН ТӨВИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД МОД ТАРИЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласан билээ. Энэхүү өдрийг тохиолдуулан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ажилтнууд Нийслэлийн хот тохижилтын газартай хамтран Турк, Монголын найрамдлын цэцэрлэгт хүрээлэнд 25 ширхэг мод суулгах ажлыг зохион байгууллаа.



# САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТОЙМ







# САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТОЙМ

МХБ-ийн бизнесийн үндсэн үйл ажиллагаа, түүний үр дүн, санхүүгийн нөхцөл байдал болон үйл ажиллагаанд нөлөөлж болох тодорхойгүй байдал, гол эрсдэлүүдийн талаар мэдээллийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн гаргасан, аудитлагдсан санхүүгийн тайлан, мэдээлэлд үндэслэн бэлтгэлээ.

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

МХБ нь “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн дагуу үнэт цаасыг бүртгэх, тэдгээрийн арилжааг зохион байгуулах, үнэт цаасны компаниудыг гишүүнээр элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэгтэйгээс гадна бусад хуулиар хориглоогүй үйл ажиллагаа явуулах эрхтэй байдаг. Түүнчлэн, хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж энэхүү ажиллагааг улам бэхжүүлж ажилладаг.

Хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын хувьд “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос (СЗХ) үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Энэхүү үйл ажиллагаа нээлттэй, ил тод, үр ашигтай явагдаж байгаа эсэхэд СЗХ хяналт тавьдаг. Мөн, МХБ нь 100% төрийн өмчит хувьцаат компани тул санхүү, эдийн засаг, зорилтот түвшингийн биелэлт, төрийн өмчийн хөрөнгийн захиран зарцуулалтад “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”, компанийн хувьцаа эзэмшигч Сангийн яам хяналт шалгалт хийдэг.

МХБ-ийн үндсэн чиг үүргийн хүрээнд төвлөрүүлсэн үйл ажиллагааны орлогыг ерөнхийд нь арилжааны шимтгэл, жилийн хураамж, үйлчилгээний хөлс болон бусад орлого гэсэн 3 ангилалд хувааж үздэг. Дараах хэсгүүдэд эдгээр орлогын төрлүүдийг дэлгэрэнгүй тайлбарласан болно.

## ОРЛОГО, ҮР ДҮН

**Орлогын тайлангийн хураангуй**

| | 2019 он сая.₮ | 2018 он сая.₮ | Өөрчлөлт ₮ | % |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 1,481.3 | 1,698.7 | (217.5) | (13) |
| Үйл ажиллагааны зардал | 1,928.3 | 2,378.3 | (450.0) | (19) |
| **Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг** | **(447.1)** | **(679.6)** | **232.5** | **(34)** |
| Элэгдэл | 737 | **631.3** | 105.8 | 17 |
| **Хүү, татварын өмнөх ашиг** | **1,184.1** | **(1,310.9)** | **126.8** | **(10)** |
| Хүүгийн орлого | 69.1 | 94.6 | (25.5) | (27) |
| **Татварын өмнөх ашиг** | **(1,115.0)** | **(1,216.2)** | **101.2** | **(8)** |
| Орлогын албан татварын зардал | 6.9 | 9.4 | (2.6) | (27) |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **(1,121.9)** | **(1,225.7)** | **103.8** | **(8)** |
| Ханшийн зөрүүгийн ашиг | (33.1) | (34.1) | (1.0) | (3) |
| **Цэвэр ашиг** | **(1,155.1)** | **(1,259.8)** | **104.8** | **(8)** |
| Нэгж хувьцаанд ногдох боломжит цэвэр ашиг | - | - | - | - |
| Нэгж хувьцаанд ногдох суурь цэвэр ашиг | - | - | - | - |
| Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг | - | - | - | - |

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Үйл ажиллагааны орлого 13%-иар буурч 1,481.3 сая төгрөгт хүрсэн.

Чөлөөт мөнгөн хөрөнгийн хүүгийн орлого үйл ажиллагааны орлогод ороогүй бөгөөд тус орлогоос 2018 онд 94.6 сая төгрөг, 2019 онд 69.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

| | 2019 он сая.₮ | 2018 он сая.₮ | Өөрчлөлт ₮ | Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|
| Арилжааны шимтгэл | 792.0 | 987.2 | (195.2) | (20) |
| Хураамж, үйлчилгээний хөлс | 487.4 | 517.0 | (29.6) | (6) |
| Бусад | 201.9 | 194.6 | 7.3 | 4 |
| **Үйл ажиллагааны орлого** | **1,481.3** | **1,698.7** | **(217.5)** | **(13)** |

Орлогын төрөл тус бүрийн үйл ажиллагааны орлогод эзлэх хувийн жинг дараах графикаар үзүүлэв.

**Үйл ажиллагааны орлогын бүтэц 2019 онд**




### Арилжааны шимтгэл

Хувьцааны ердийн арилжааны өдрийн дундаж үнийн дүн сүүлийн жилүүдэд тогтмол өсч байгаа боловч багцын арилжааны дүн 2019 онд 56%-иар эрс буурсан, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй, зөвхөн 9.7 тэрбум төгрөгийн дүн бүхий ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа хийгдсэн зэргээс шалтгаалан арилжааны шимтгэлийн орлого 20%-иар багассан байна. Багцын арилжаа нь бүртгэлтэй компанийн үнэт цаасны 250 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй, эсхүл тухайн компанийн гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүнтэй, МХБ-ийн захиалгын сангаас гадуур хэлэлцэн тохирсон, арилжааны системд мэдээлэгдэж байгаа арилжаа юм.

### Хураамж, үйлчилгээний хөлс

Хураамж, үйлчилгээний орлого нь бүртгэлтэй компанийн тоо, тэдгээрийн зах зээлийн үнэлгээ, үнэт цаас гаргаж байгаа компанийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ, гишүүн брокер, дилер, андеррайтерийн компанийн тоо, гишүүдийн терминалын тооноос хамаарч өөрчлөгддөг.

Тус орлого нь 2018 оны мөн үетэй харьцуулахад 29.6 сая төгрөгөөр буурсан бөгөөд *энэхүү орлогын ангилалд хамаарах орлогын төрөл тус бүрийн өөрчлөлтийг авч үзвэл дараах байдалтай байна:*

- ✓ Хөрөнгийн зах зээлийн түүхэн дээд амжилт буюу нийт 5 компани анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгож, 1 компани нэмж хувьцаа гаргах замаар шаардлагатай санхүүжилтээ татан төвлөрүүлж зах зээл идэвхжиж байсан 2018 онтой харьцуулахад энэ онд зөвхөн 4 компани үнэт цаас гаргаснаас *бүртгэх үйлчилгээний хөлс* 43%-иар буурсан.

- ✓ Бүртгэлтэй компаниудын 2018 оны жилийн эцсийн байдлаарх зах зээлийн үнэлгээ 2017 оны мөн үеэс өссөн, 2018 онд шинээр бүртгэгдсэн компаниудын хураамжийг төвлөрүүлж эхэлсэн зэргээс шалтгаалан *2019 оны бүртгэлтэй компанийн жилийн хураамжийн* орлого 21%-иар нэмэгдсэн.

✓ 2018 онд 7, 2019 онд 2 гишүүн брокер, дилерийн компанийн зах зээлд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл цуцлагдан Биржийн гишүүнчлэлээс хасагдсанаас *гишүүнчлэлийн жилийн хураамж* 16%-иар буурсан бол 8 гишүүн "Миллениум Ай Ти" арилжааны програмд нэвтрэх терминалын тоогоо нэмэгдүүлсэн, 1 гишүүн шинээр эрх авснаар *ерминал ашигласны хураамжийн* орлого 14%-иар өссөн.

### Бусад орлого

Бусад орлогын ангилалд үнэт цаасны анхан шатны мэдлэг олгох сургалт, байгууллагууд болон ард иргэдэд төлбөртэй хүргэдэг мэдээллийн үйлчилгээ, түрээсийн орлогууд багтдаг. 2019 онд зарим мэдээллийн үйлчилгээний үнэ тариф өөрчлөгдсөн, харилцагч байгууллагуудын хүрээ тэлснээс бусад орлого 4%-иар өссөн.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2019 онд үйл ажиллагааны зардлыг 450.0 сая төгрөг буюу 19%-иар бууруулж ажилласан байна.

Үйл ажиллагааны зардалд хөрөнгийн элэгдэл, хорогдол, санхүүгийн зардал, онцгой шинжтэй зардлуудыг оруулаагүй.

| | 2019 он сая.₮ | 2018 он сая.₮ | Өөрчлөлт ₮ | Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|
| Цалин хөлс, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардал | 888.1 | 884.8 | 3.4 | (11) |
| Бусад үйл ажиллагааны зардал | 235.1 | 282.8 | (47.7) | (54) |
| MIT системийн үйлчилгээ | 805.1 | 1,210.7 | (405.6) | (33) |
| **Үйл ажиллагааны зардал** | **1,928.3** | **2,378.3** | **(450.0)** | **(19)** |

### Цалин хөлс, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардал

Цалин хөлсний зардалд МХБ-ийн 3 газар, 7 албадын нийт 50 ажилтан, мэргэжилтнүүдийн үндсэн цалин хөлс, шагнал урамшуулал, түүнд тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд багтдаг. 2019 онд цалин хөлсний зардал өнгөрсөн онтой адил түвшинд байсан.

ТУЗ-ийн цалин хөлс, ТУЗ-ийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарсан бичиг, хэрэг, материал болон гүйцэтгэх захирлын томилолт, бизнес уулзалттай холбогдох зардлуудыг ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардалд оруулан тооцсон. Томилолт, бизнес уулзалтын зардлыг хэмнэн ажилласнаас тус зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13%-иар буурсан.

### MIT системийн үйлчилгээний төлбөр

"Миллениум Ай Ти" цогц систем нь үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хяналт, хадгаламжийн дэд системүүдээс бүрддэг бөгөөд энэхүү цогц системийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэсэн тул жилд 490.2 сая төгрөгөөр хорогдуулж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд бүртгэдэг. Энэ нь санхүүгийн тайланд биет бус хөрөнгийн цэвэр дүн буурахад нөлөөлж буй гол хүчин зүйл юм.

Мөн системийн ашиглалт болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх үйлчилгээний төлбөрт жилд нийт 262,000 ам.долларыг Лондонгийн хөрөнгийн бирж группд төлөх үүрэг хүлээдэг ба түүнд ногдох ОСБНӨАТ-ын 10%-ийг МУ-ын татварт хуулийн хугацаанд тайлагнаж, төлдөг болно. 2017 онд дууссан "Үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх гэрээ"-ний сунгалтыг 2018 онд баталгаажуулсантай холбоотой гэрээний 2017 онд хамаарах төлбөрийг 2018 онд санхүүгийн тайланд хуримтлуулан бүртгэснээс 2018 оны бодит зардал нь 783.5 сая төгрөг ба 2019 онд уг үйлчилгээний зардал валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан 2.8%-аар өссөн.

### Бусад үйл ажиллагааны зардал

МХБ үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбогдон гарах урсгал зардлууд, маркетинг, бизнес харилцаа, сургалтын зардлуудыг бусад үйл ажиллагааны зардалд хамруулсан. МХБ-ийн үйл ажиллагаа, ахиц дэвшил, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэргийг нийгмийн цахим сүлжээг түлхүү ашиглан, урсгал зардлыг хэмнэн ажилласнаар 2018 оны гүйцэтгэлээс 47.4%-иар бууруулсан.

## САНХҮҮГИЙН БАЙДАЛ

2019 оны жилийн эцсийн байдлаар МХБ-ийн цэвэр хөрөнгийн дүн 35%-иар буурч 2,182.3 сая төгрөгт хүрсэн.

### Балансын хураангуй

| | 2019 он сая.₮ | 2018 он сая.₮ | Өөрчлөлт ₮ | % |
|---|---|---|---|---|
| Хөрөнгө | | | | |
| Мөнгө | 953.4 | 830.4 | 123.0 | 15 |
| Дансны авлага, санхүүгийн хөрөнгө | 51.0 | 300.5 | (249.4) | (83) |
| Бараа материал | 24.6 | 26.3 | (1.8) | (7) |
| Урьдчилж төлсөн зардал | 8.3 | 16.9 | (8.6) | (51) |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 13.2 | 13.2 | 0.0 | 0 |
| Үндсэн хөрөнгө | 2,083.7 | 2,172.0 | (88.3) | (4) |
| Биет бус хөрөнгө | 653.0 | 1,192.7 | (539.7) | (45) |
| Нийт хөрөнгө | 3,787.3 | 4,552.0 | (764.7) | (17) |
| Өр төлбөр | | | | |
| Дансны өглөг | 1,541.4 | 1,052.0 | 489.4 | 47 |
| Бусад өглөг | 63.5 | 162.6 | (99.1) | (61) |
| Нийт өр төлбөр | 1,605.0 | 1,214.6 | 390.3 | 32 |
| Эздийн өмч | | | | |
| Төрийн өмч | 23,130.6 | 23,130.6 | 0.0 | 0 |
| Хуримтлагдсан ашиг | (21,407.0) | (20,251.9) | (1155.1) | 6 |
| Эзний өмчийн бусад хэсэг | 446.3 | 446.3 | 0.0 | 0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 12.0 | 12.0 | 0.0 | 0 |
| Нийт эздийн өмч | 2,182.3 | 3,337.3 | (1155.1) | (35) |

### Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын хэмжээ 2018 онтой харьцуулахад 76%-иар буурсан.

Компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд хөрөнгө оруулалтыг 404.7 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд тайланд хугацаанд, гүйцэтгэлээр 109.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 93.0 сая төгрөгийг “Миллениум Ай Ти” арилжаа, төлбөр, тооцоо, хяналт, хадгаламжийн цогц системийн аюулгүй байдал, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор өгөгдлийн сангийн “Oracle” лицензийн жилийн сунгалт үйлчилгээнд зарцуулсан. Энэ нь нийт хөрөнгө оруулалын 85%-ийг дангаар эзэлж байна.

Мөн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд туссан серверийн өрөөний гал унтраах төхөөрөмж болон серверийн бүрэн шинэчлэлийн худалдан авалтууд, мөн сүлжээний свичийн шинэчлэлийн холбогдох тендерүүд тайлант хугацаанд амжилттай хийгдсэн бөгөөд холбогдох хууль, журам, гэрээний дагуух гүйцэтгэл нь он дамнаж байгаа буюу нийт 188.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгжихээр хүлээгдэж байгаа болно.

### Өр төлбөр

“Миллениум Ай Ти” арилжаа, төлбөр, тооцоо, хяналт, хадгаламжийн цогц системийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээний 2018 ба 2019 оны төлбөрүүд нь санхүүгийн тайланд нийт өр төлбөрийн 95%-ийг эзэлж байна.

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ






# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

## ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй бөгөөд “Ил тод, нээлттэй зах зээлийн тогтолцоог бэхжүүлж, санхүүгийн төрөлжсөн хэрэгслүүд бүхий хөрвөх чадвар сайтай, бүс нутагт өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг бий болгох” алсын хараны хүрээнд 2019-2021 оны үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажилласан. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан.

ТУЗ-ийн үүргийг “Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д тодорхой заасан.

## ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”- аар зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

**Аудитын хорооны бүрэлдэхүүн**

| | |
|---|---|
| А. Батпүрэв | Хорооны дарга |
| А. Анар | Гишүүн |

**Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн**

| | |
|---|---|
| Б. Сүх-Очир | Хорооны дарга |
| Р. Гандиймаа | Гишүүн |
| А. Анар | Гишүүн |

## ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг.

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагаар хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг.

Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

**Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн**

| | |
|---|---|
| Л. Сонор | Хорооны дарга |
| Р. Гандиймаа | Гишүүн |
| А. Батпүрэв | Гишүүн |

Нэр дэвшүүлэх хороо 2019 онд 1 удаа хуралдаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга М.Санжаадорж нарыг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэн Хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан бөгөөд ТУЗ шинэ 2 гишүүний бодлого, стратеги төлөвлөлтийн талаарх ажлын туршлага, ур чадвар нь ТУЗ-ийн одоогийн бүтэц, бүрэлдэхүүний ур чадвар, туршлагыг улам чанаржуулах, үнэ цэнэ нэмэх ач холбогдолтой гэж үзсэн байна.

## ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 1 жилийн хугацаатай сонгодог бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог.

2019 онд ТУЗ-ийн дарга М.Батхуяг, гишүүн Б.Сүх-Очир, Л.Сонор, Д.Баянзул, Р.Гандиймаа, А.Батпүрэв, А.Анар нар улиран сонгогдсон бол гишүүн М.Аясгалан, С.Ганзориг нарыг чөлөөлж, Б.Ганбат, М.Санжаадорж нарыг шинээр томилсон байна.

## ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг 2018 оны 7 сард томилсон ба холбогдох гэрчилгээг авсан байна. 2019 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт ороогүй.

## *Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг*

МХБ-ийн гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлагын талаар Компанийн дүрэмд тодорхой заасан байдаг. Гүйцэтгэх захирал нь МХБ-ийн өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-өөс баталсан үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

ТУЗ-ийн 2017 оны 10 сарын 2-ны өдөр байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-г сунгахаар шийдвэрлэсний дагуу тайлант хугацаанд гүйцэтгэх захирлаар Х.Алтай ажилласан. 2019 онд МХБ-ийн 2019-2021 оны дунд хугацааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2019 оны бизнес төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, холбогдох дүрэм журмыг боловсруулж ажилласан.

## *Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх*

Гүйцэтгэх захирал Х.Алтай ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд МХБ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг жил тутам үнэлэн дүгнэлт гаргадаг.

Төрийн өмчийн хорооноос баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журам”-ын дагуу Гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэхдээ үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, эрсдэлийг удирдсан байдал, санхүүгийн зорилго, зорилтын биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт зэргийг төлөвлөлттэй харьцуулдаг.

2019 онд санхүүгийн зорилго, зорилтод хамаарагдах үзүүлэлт 82% гүйцэтгэлтэй байсан бол үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт хангалттай түвшинд байв.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА, БҮТЭЦ, УР ЧАДВАР

### ТУЗ-ийн танилцуулга

| | Одоогийн эрхэлж буй албан тушаал | Гишүүнээр томилогдсон огноо |
|---|---|---|
| **М. Батхуяг**<br>ТУЗ-ийн дарга<br>Олон улсын санхүү-эдийн засгийн магистр | Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга | 2018/03/26 |
| **Б.Ганбат**<br>Ердийн гишүүн<br>Хууль эрхзүйн магистр | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга | 2019/07/23 |
| **Б.Сүх-Очир**<br>Ердийн гишүүн | Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга | 2018/03/26 |
| **Л.Сонор**<br>Ердийн гишүүн | Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга | 2018/03/26 |
| **М.Санжаадорж**<br>Ердийн гишүүн<br>Магистр | Сангийн яамны Төсөвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга | 2019/07/23 |
| **Д.Баянзул**<br>Ердийн гишүүн<br>Олон улсын эдийн засгийн магистр | Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны захирал | 2018/03/26 |
| **Р. Гандиймаа**<br>Хараат бус гишүүн<br>Сэтгүүлзүйн магистр | Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн захирал | 2018/07/04 |
| **А. Батпүрэв**<br>Хараат бус гишүүн<br>Санхүү-эдийн засгийн магистр | “Скайтел групп” ХХК-ийн Стратеги, удирдлагын газрын захирал | 2018/07/04 |
| **А. Анар**<br>Хараат бус гишүүн | “МИК ОССК” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал | 2018/07/04 |

## ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ нь компанийн 100% хувьцаа эзэмшигч болох Сангийн яамыг төлөөлсөн 9 гишүүнтэй байсан бөгөөд 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүд байв.

2019 онд ТУЗ-ийн нийт гишүүдийн 33% нь эмэгтэй гишүүд байв. Гишүүдийн МХБ-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажилласан хугацаа болон насны бүтцийг дараах графикаар үзүүллээ.

**Гишүүдийн нас**

- 30-39
- 40-50
- 51-60




**Гишүүнээр ажилласан хугацаа**

- 0-3
- 4-6
- >7




## Гишүүдийн ур чадварын матриц

| Төрөл | Тайлбар | Эдгээр ур чадвар бүхий гишүүд | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Манлайлал | Гүйцэтгэх удирдлагын чиглэлээр амжилттай ажилласан туршлага | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| Стратеги | Стратегийн зорилго, зорилтыг тодорхойлох, бизнес төлөвлөгөө судлах, шинжлэх, стратегийг хэрэгжүүлэх | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| Санхүүгийн ур чадвар | Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал, компанийн санхүү болон дотоод хяналт | ■ | ■ | | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| Эрсдэл ба комплаенс | Үйл ажиллагааны үндсэн эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг хянах | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| Төрийн/Нийтийн удирдлага | Зах зээл болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх зохицуулалт | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| Мэдээллийн технологи | Мэдээллийн технологийн дэд бүтэц, хэрэглээ, засаглал | ■ | | | | | | | | ■ |
| Бизнесийн хөгжил, харилцагчийн удирдлага | Бизнесийн туршлага (шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, харилцагчийн удирдлагын стратеги, болон инноваци) | | | | ■ | ■ | ■ | | ■ | ■ |
| Хувь хүний хөгжлийн удирдлага | Удирдлагын баг, цалин урамшууллын тогтолцоо, хүний нөөцийн удирлага болон стратегийг үнэлэх, хянах | | | | ■ | ■ | ■ | | | ■ |
| Компанийн засаглал | Компанийн засаглалын чиглэлээрх мэдлэг, туршлага, болон ажилласан байдал | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| Олон улсын хөрөнгийн зах зээлийн туршлага | Олон улсын санхүүгийн зах зээл, хөрөнгийн бирж/групп, эсхүл бусад мэргэжлийн оролцогч байгууллагуудтай хамтран ажилласан байдал | ■ | ■ | ■ | | | ■ | | ■ | |
| Санхүүгийн үйлчилгээний чиглэлээр ажилласан туршлага | Брокер дилерийн компани, хөрөнгө оруулалтын менежментийн компани, банк, хөрөнгө оруулалтын банк г.м | | ■ | | | | ■ | | | |

### ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлага

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах гишүүдийн хамтын ур чадварт байж болох ур чадварын дутуу орон зайг илрүүлэх, гишүүдийн ур чадвар, ажлын туршлагыг үнэлэх зорилгоор дээрх хүснэгтээр харуулсан матрицыг хэрэглэдэг.

Гишүүдийн салбарын мэдлэг туршлага, мэргэжлийн ур чадвар болон хүйсийн тэнцвэртэй харьцааг хадгалах нь МХБ-д тулгарч байгаа асуудал, сорилтуудыг оновчтойгоор шийдвэрлэх, гүйцэтгэх захирал болоод удирдлагын багийн бусад гишүүд үйл ажиллагааны стратеги төлөвлөлтийг хэрхэн хэрэгжүүлж байгаад бодит үнэлгээ, дүгнэлт өгөхөд чухал үүрэгтэй.

ТУЗ өөрийн бүтэц, бүрэлдэхүүнийг зохих түвшинд байна гэж үзсэн бөгөөд компанийн сайн засаглалын зарчмын дагуу ур чадвар, бүтэц, бүрэлдэхүүний тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж ирсэн.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - хурлын ирц, сургалт

### ТУЗ-ийн гишүүдийн сургалт, танилцуулга

“Компанийн тухай хууль”-ийн 75.9 дэх зүйлд заасны дагуу МХБ-ийн ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж, сургалтын гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагын дагуу 2019 онд шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүд болох Б.Ганбат, М.Санжаадорж нар компанийн засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээг авсан байна.

Мөн 2019 онд Монгол дахь Азийн сан болон “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ хамтран зохион байгуулсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх талаар сургалтад ТУЗ-ийн бүх гишүүд оролцлоо.

### Гишүүд ТУЗ-ийн хуралд оролцсон байдал

ТУЗ нь Сангийн сайдын 2014 оны 6-р сарын 23-ны өдрийн тушаалаар шинэчлэн баталсан “Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн дүрэм” болон МХБ-ийн 2013 оны 5-р сарын 10-ны өдрийн тогтоолоор шинэчлэн баталсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. 2019 онд ТУЗ нийт 6 удаа хуралдсан бөгөөд үүнээс 2 нь албан бус хурал байв. ТУЗ-ийн хурлаар нийт 17 асуудал хэлэлцэн, компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн дотоод ажилтай холбоотой 13 тогтоол гаргаж, 8 тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад үүрэг, даалгавар өгч ажилласан.

ТУЗ-ийн бүх хурал Улаанбаатар хотод Сангийн яам болон МХБ-ийн хурлын танхимд зохион байгуулагдсан бөгөөд хурлын ирцийг дараах хүснэгтээр харуулав.

| | ТУЗ-ийн хурал | | Аудитын хорооны хурал | | | Нэр дэвшүүлэх хорооны хурал | | | Цалин, урамшууллын хорооны хурал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Гишүүний нэр | З/Б | Б/О | [1] З/Б | [2] Б/О | [3] Б/Х | З/Б | Б/О | Б/Х | З/Б | Б/О | Б/Х |
| М.Батхуяг | 6 | 6 | | | | | | | | | |
| Б.Ганбат | 6 | 6 | | | | | | | | | |
| Б.Сүх-Очир | 6 | 6 | | | | | | | 1 | 1 | |
| Л.Сонор | 6 | 6 | | | | 1 | 1 | | | | |
| М.Санжаадорж | 6 | 6 | | | | | | | | | |
| Д.Баянзул | 6 | 6 | | | | | | | | | |
| Р.Гандиймаа | 6 | 6 | | | | 1 | 1 | | 1 | 1 | |
| А.Батпүрэв | 6 | 6 | 5 | 5 | | 1 | 1 | | | | |
| А.Анар | 6 | 6 | 5 | 5 | | | | | 1 | 1 | |

[1] Зохион байгуулсан [2] Биечлэн оролцсон [3] Бусад хэлбэрээр оролцсон

### Цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол цалин хөлс олгодог. МХБ-ийн ТУЗ-ийн ердийн гишүүд нь Сангийн яаманд ажилладаг төрийн албан хаагч нар байдаг бөгөөд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч цалин хөлснөөс бусад шан харамж, урамшуулал авахыг хориглодог тул ердийн гишүүний цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг.

ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын дагуу тогтоодог бөгөөд гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг.

МХБ-ийн хараат бус гишүүдийн цалин урамшууллын бүтэц ердийн гишүүдийн цалин урамшууллын бүтэцтэй адил байдаг.

ТУЗ-ийн гишүүнд зуучлалын хөлс, зөвлөх үйлчилгээний хөлс зэрэг бусад төлбөр, нөхөн олговор олгодоггүй. 2019 онд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин хөлсийг дараах хүснэгтээр харуулав.

| Гишүүний нэр | 2019 оны цалин хөлс мян.₮ |
|---|---|
| М. Батхуяг | 5,760.0 |
| Б. Ганбат | 2,300.0 |
| Б. Сүх-Очир | 5,520.0 |
| Л. Сонор | 5,520.0 |
| М. Санжаадорж | 2,300.0 |
| Д. Баянзул | 5,520.0 |
| Р. Гандиймаа | 5,520.0 |
| А. Батпүрэв | 5,520.0 |
| А. Анар | 5,520.0 |

## АУДИТ, ХЯНАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

### Хараат бус аудит

МХБ-ийн ТУЗ-ийн аудитын хорооноос шалгаруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн сонгосон хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага болох "Кэй Пи Эм Жи Аудит" ХХК-тай 2016 онд "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулж, санхүүгийн үйл ажиллагаанд 4 жил дараалан санхүүгийн аудит хийсэн бөгөөд "Аудитын тухай хууль"-ийн 8.1 дэх зүйлд "нэг аудитын хуулийн этгээд нэг байгууллагад дараалсан 5 жилээс илүү хугацаанд аудитын үйлчилгээ үзүүлэхийг хориглоно" гэж заасны дагуу тус компанитай байгуулсан гэрээг цуцалж, 2019 онд "Грант торнтон аудит" ХХК-ийг хараат бус аудитын байгууллагаар сонгосон.

Тус аудитын байгууллага МХБ-ийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг шалган санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнг үнэн зөв илэрхийлсэн, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон компанийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдсөн эсэх талаар дүгнэлт гаргах үүрэгтэй.

Аудитын баг нь МХБ-ээс ажил төрөл, хувийн харилцаа холбооны хувьд мөн аудитын үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байсан тухайгаа илэрхийлсэн.

Хараат бус аудитын дүгнэлтийг 47-72 хуудаснаас үзнэ үү.

### Ашиг сонирхлын зөрчил

Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Мэдээллийн ил тод байдлын журам"-ын дагуу гишүүд эзэмшиж байгаа үнэт цаасны талаарх мэдээллийг ил тод танилцуулах үүрэгтэй. Гишүүн ТУЗ-ийн хэлэлцэх асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд тухайн асуудлыг хэлэлцэх болон санал өгөхөд оролцдоггүй.

### Гишүүдийн бие даасан байдал

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд хараат бус гишүүн олон байх нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт эерэг нөлөөтэй. МХБ-ийн ТУЗ нь "Компанийн тухай хууль"-ийн 75.4 дэх заалтын дагуу хараат бус 3 гишүүнтэй байна.

Нэр дэвшүүлэх хороо шинэ гишүүний танилцуулга, холбогдох баримт материалыг "Авилгатай тэмцэх газар"-т /АТГ/ хүргүүлэн гишүүний бие даасан байдлыг тодорхойлуулдаг. АТГ нь гишүүд хувьцаа эзэмшигчдийн эрх

ашгийн төлөө ажиллахад, мөн бие даасан үйл ажиллагаа явуулахад материаллагаар нөлөөлж болох ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг хянаж шалгадаг.

## Мэдээллийн ил тод байдал

МХБ нь үнэт цаасны 3 дугаар ангилалд бүртгэлтэй компани тул Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэн нийтэд толилуулах үүрэгтэй.

“Компанийн тухай хууль” болон “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн дагуу хувьцаа эзэмшигч, зах зээлд оролцогч байгууллагууд болон иргэдийг жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааны тойм танилцуулга, сар тутмын гол үйл явдлуудын эмхэтгэл болох и-сонин зэрэг үйл ажиллагааны мэдээллээс гадна хөрөнгийн зах зээлийн өдөр тутмын үйл явдлын мэдээ, мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан Монгол, Англи хэл дээр тогтмол хүргэдэг бөгөөд олон нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг тухайлчлан зарим этгээдэд мэдээлдэггүй.

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

1991 ОНЫ 01 САРЫН 18-НД БАЙГУУЛАГДСАН

www.facebook.com/mongolian stock exchange

TOP-20 ИНДЕКС

MSE A ИНДЕКС

www.mse.mn

НОГДОЛ АШИГ

БРОКЕР & ДИЛЕР

**Монголын хөрөнгийн бирж**

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

КОМПАНИЙН БОНД

MSE B ИНДЕКС

ЗЗҮ 2.7 ИХ НАЯД

I САМБАР

АРИЛЖАА

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн

54 ГИШҮҮН

ӨГӨӨЖ

II САМБАР

MIT СИСТЕМ

УУГАН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА

ХУВЬЦАА

ҮНЭТ ЦААС

198 БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИ

# ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

## Хувьцааны бүртгэл

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д 2019 оны 12 сарын 31-ний байдлаар 198 ХК бүртгэлтэй байгаагаас 9.0% буюу 18 ХК нь 100 хувь төрийн өмчит, 5.1% буюу 10 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 85.9% буюу 170 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна.

Бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 12.8 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 31.0% буюу 3.9 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 69.0% буюу 8.8 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.




## Бүртгэлтэй компаниудын салбарын ангилал, компанийн тоо

| | | | |
|---|---|---|---|
| Геологи | 5 | Тээвэр | 10 |
| Уул уурхай | 12 | Нийтийн хангамж | 17 |
| Хүнд үйлдвэрлэл | 4 | Худалдаа | 19 |
| Ойн аж ахуй | 5 | Үйлчилгээ | 9 |
| Хөдөө аж ахуй | 25 | Хэвлэл мэдээлэл | 1 |
| Хүнсний үйлдвэрлэл | 19 | Харилцаа холбоо | 1 |
| Хөнгөн үйлдвэрлэл | 13 | Санхүү | 16 |
| Барилгын материал үйлдвэрлэл | 13 | Үл хөдлөх хөрөнгө | 12 |
| Барилга, зам угсралт | 16 | Технологи | 1 |

## Шинээр бүртгэгдсэн компаниуд

2019 онд Монголын хөрөнгийн биржид шинээр үнэт цаас бүртгүүлэхээр 3 компани хүсэлтээ ирүүлснийг судалж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох шийдвэр, дүгнэлтийг хүргүүлснээс

“Инвескор ББСБ” ХК, “Мост Финтек” ХК-иудын зөвшөөрөл гарсан хэдий ч “Мост Финтек” ХК нь анхдагч зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгохгүйгээр буцаан хасуулах хүсэлтээ өгсний дагуу шийдвэрлэсэн.

Харин 2018 онд МХБ болон СЗХ-ны холбогдох шийдвэр гарсан хэдий ч анхдагч арилжаа явагдаагүй “Түмэн шувуут” ХК, 2019 онд СЗХ-ны холбогдох шийдвэр гарсан “Ард кредит ББСБ” ХК, “Монос хүнс” ХК, “Инвескор ББСБ” ХК-иуд МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 42.4 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.

| Компанийн нэр | Бүртгэгдсэн хувьцааны тоо | Биржид бүртгэгдсэн огноо | Олон нийтэд эзэмшүүлсэн хувьцааны тоо | Татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн, ₮ |
|---|---|---|---|---|
| “Түмэн шувуут” ХК | | 2018.08.16 | 50,000,000 | 10,000,000,000 |
| “Ард кредит ББСБ” ХК | 280,000,000 | 2018.11.30 | 70,000,000 | 5,285,000,000 |
| “Монос хүнс” ХК | 408,850,428 | 2018.12.17 | 122,665,128 | 8,586,558,960 |
| “Инвескор ББСБ” ХК | 71,727,918 | 2019.03.26 | 10,759,188 | 18,586,497,300 |
| “Мост финтек” ХК | 466,716,642 | 2019.03.19 | | |
| “Бодь даатгал” ХК | 235,319,718 | 2019.08.28 | | |

## Бүртгэлээс хасагдсан компаниуд

| Компанийн нэр | Хувьцааны тоо | Хасагдсан огноо | Хасагдсан үндэслэл |
|---|---|---|---|
| “Сав шим” ХК | 183,780 | 2019.03.05 | Хөрөнгийн биржийн шалгуур, шаардлага хангаагүй тул хаалттай ХК болсон |
| “Алмаас” ХК | 515,149 | | |
| “Ар тархи” ХК | 23,726 | | |
| “Баялаг шарын гол” ХК | 74,160 | | |
| “Баянтоорой” ХК | 356,594 | | |
| “Бүтээл” ХК | 231,723 | | |
| “Дорнод тээвэр” ХК | 66,821 | | |
| “Еврофё Азиа” ХК | 607,809 | | |
| “Жинст” ХК | 59,460 | | |
| “Их нуур ХК | 55,962 | | |
| “Их үүсгэл ХК | 181,571 | | |
| “Мөнх жим” ХК | 159,977 | | |
| “Мон-Асар” ХК | 71,086 | | |
| “Өв-Усжуулагч” ХК | 102,394 | | |
| “Сэлэнгэ импекс” ХК | 156,525 | | |
| “Төв Ус” ХК | 159,781 | | |
| “Хангал” ХК | 193,712 | | |
| “Харгиа” ХК | 88,483 | | |
| “Харшийн гэгээ ХК | 209,210 | | |
| “Чандмань уул ХК | 91,759 | | |
| “Чандмань Дундговь” ХК | 72,073 | | |
| “Баялаг Налайх” ХК | 311,872 | 2019.05.28 | Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр ХХК болсон |
| “Мост финтек” ХК | 466,716,642 | 2019.11.06 | Анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй, хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр ХХК болсон |

## Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон компаниуд

| Компанийн нэр | Шийдвэрийн огноо | Бүртгэлийн өөрчлөлт |
|---|---|---|
| “Жинст-Увс” ХК | 2019.05.08 | "Жинст-Увс" ХК-д "Ард санхүүгийн нэгдэл" ХХК-ийг нэгтгэн хувьцааны тоо 26,948,325 ширхгээр нэмэгдэж, оноосон нэр "Ард санхүүгийн нэгдэл" ХК болж өөрчлөгдсөн |
| “Хорго хайрхан” ХК | 2019.08.20 | "Хорго хайрхан" ХК-д "Монгол даатгал" ХХК-ийг нэгтгэн хувьцааны тоо 63,997,215 ширхгээр нэмэгдэж, оноосон нэр "Монгол даатгал" ХК болж өөрчлөгдсөн |
| “Мандал даатгал” ХК | 2019.06.05 | Нэгж хувьцааг 100 хувааж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан |
| “Баян-Алдар” ХК | 2019.11.22 | Нэгж хувьцааг 50 хувааж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан |
| “Дархан гурил тэжээл” ХК | 2019.11.22 | Нэгж хувьцааг 1000 хувааж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан |

## Засгийн газрын үнэт цаасны бүртгэл

Тайлант хугацаанд Сангийн яамнаас дотоодын зах зээлд Засгийн газрын үнэт цаас гаргахгүй байх төсөв, санхүүгийн бодлогыг баримталсантай холбоотой биржид шинээр нэмж ЗГҮЦ-ыг бүртгээгүй буюу анхдагч зах зээлийн арилжаа хийгээгүй. Харин 56.8 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж 568,515 ширхэг ЗГҮЦ-ыг биржийн бүртгэлээс хассан.

## Бүртгэлтэй үнэт цаасны тоон мэдээлэл

| Үзүүлэлт | 12/31/2019 | 12/31/2018 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Бүртгэлтэй компанийн тоо | 198 | 217 | (19) |
| Төрийн өмчит | 28 | 29 | (1) |
| Хувийн өмчийн | 170 | 188 | (18) |
| Бүртгэлтэй үнэт цаасны тоо | 12,861,663,350 | 11,396,054,507 | 1,465,608,843 |
| Төрийн өмчид | 3,986,616,757 | 3,986,710,485 | (93,728) |
| Олон нийтэд | 8,875,046,593 | 7,409,344,022 | 1,465,702,571 |
| Үнэт цаас шинээр бүртгүүлсэн ХК | 3 | 6 | (3) |
| Төрийн өмчит | - | - | - |
| Хувийн өмчийн | 3 | 6 | (3) |
| Шинээр бүртгүүлсэн үнэт цаасны тоо | 1,227,294,988 | 1,091,660,016 | 135,634,972 |
| Нэмж үнэт цаас гаргасан ХК | - | 3 | (3) |
| Нэмж бүртгүүлсэн үнэт цаасны тоо | - | 22,871,536 | (22,871,536) |
| Үнэт цаасны тоонд өөрчлөлт орсон бусад ХК | 3 | 3 | - |
| Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсноор нэмж бүртгэгдсэн үнэт цаасны тоо | 709,004,124 | 803,246,689 | (94,242,565) |
| Бүртгэлээс хасагдсан ХК | 23 | 7 | 16 |
| Хасагдсан үнэт цаасны тоо | 470,690,269 | 1,753,895,085 | (1,283,204,816) |

# ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцааг 133.5 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 97.4 мянган ширхэг үнэт цаасыг 9.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 143.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 93.3%-ийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 6.7%-ийг ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

| **Үнэт цаасны төрөл** | **Арилжигдсан тоо хэмжээ /мянган ширхэг/** | **Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/** |
|---|---|---|
| Хувьцаа: | | |
| Анхдагч зах зээл | 253.4 | 42.4 |
| Хоёрдогч зах зээл | 196.9 | 91.1 |
| Засгийн газрын үнэт цаас: | | |
| Хоёрдогч зах зээл | 0.097 | 9.7 |
| **Нийт** | **450.4** | **143.2** |

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 570.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.8 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүнг сүүлийн 5 жилээр харьцуулан харуулбал:

| **Үнэт цаасны төрөл** | **2015 он** | **2016 он** | **2017 он** | **2018 он** | **2019 он** |
|---|---|---|---|---|---|
| Хувьцаа | 30.5 | 49.0 | 76.4 | 210.0 | 133.5 |
| Засгийн газрын үнэт цаас | 515.5 | 299.6 | 772.5 | 33.5 | 9.7 |
| Компанийн бонд | 0.5 | 0 | 10.2 | 0.6 | 0 |
| **Нийт** | **546.5** | **348.6** | **859.1** | **244.1** | **143.2** |

## Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцааг 133.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан. Хувьцааны арилжааны 41.87% буюу 55.9 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 31.8% буюу 42.4 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 3.5% буюу 4.6 тэрбум төгрөгийг тендер арилжаа, 22.8% буюу 30.5 тэрбум төгрөгийг энгийн арилжаа тус тус эзэлж байна.

### Хувьцааны арилжааны үзүүлэлтүүд:



## Анхдагч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд хувьцааны анхдагч зах зээлд нийт 4 компанийн 42.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 253.4 сая ширхэг хувьцааг нийтэд санал болгон амжилттай арилжсан байна. Үүнд: 2019 оны 2 дугаар сард “Түмэн шувуут” ХК-ийн 50.0 сая ширхэг хувьцааг 10.0 тэрбум төгрөгөөр, 3 дугаар сард “Ард кредит ББСБ” ХК-ийн 70.0 сая ширхэг хувьцааг 5.2 тэрбум төгрөгөөр, 5 дугаар сард “Монос хүнс” ХК-ийн 122.6 сая ширхэг хувьцааг 8.5 тэрбум төгрөгөөр, 6 дугаар сард “Инвескор ББСБ” ХК-ийн 10.7 сая ширхэг хувьцааг 18.5 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд амжилттай арилжсан байна.

**Нийт хувьцааны арилжаанд эзлэх хувь:**




## Багцын арилжаа

Тайлант хугацаанд багцын арилжаагаар Хот девелопмент, Хөвсгөл алтандуулга, Лэндмн ББСБ, Баялаг-Сүмбэр, Түмэн шувуут, Хүннү менежмент, Даваанбулаг, Мон-Ит Булигаар, Мик холдинг, АПУ, Инвескор ББСБ, Улаанбаатар хивс зэрэг ХК-иудын нийт 48.2 сая ширхэг хувьцаа 55.9 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 41.87%-ийг эзэлж байна.

## Тендер саналын арилжаа

Тайлант хугацаанд тендер саналын арилжаагаар "Мон-Ит Булигаар" ХК-ийн 6,301 ширхэг хувьцаа хувьцааг 47.4 сая төгрөгөөр, “Атар Өргөө” ХК-ийн 76,756 ширхэг хувьцааг 4.6 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

## Засгийн газрын үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 97.4 мянган ширхэг үнэт цаас 9.7 тэрбум төгрөгөөр арилжигдсан байна.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Новел инвестмент ҮЦК” ХХК, “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК, “Голомт капитал ҮЦК” ХХК, “Тэнгэр капитал ҮЦК” ХХК, “Стандарт инвестмент ҮЦК” ХХК, “Гаули ҮЦК” ХХК, “Централ секьюритийз ҮЦК” ХХК, “Стандарт инвестмент ҮЦК” ХХК зэрэг үнэт цаасны компаниуд идэвхитэй оролцсон байна.

## Ханшийн өсөлттэй 20 үнэт цаас

| Үнэт цаас | 2019.12.31 | 2018.12.31 | Ханшийн өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | нэгж | % |
| Дархан гурил тэжээл | 4243 | 920 | 3323 | 361 |
| Хүннү менежмент | 427.89 | 185 | 242.89 | 131 |
| Эрчим баян өлгий | 1000 | 460 | 540 | 117 |
| Хүрд | 4279 | 2128 | 2151 | 101 |
| Улсын их дэлгүүр | 977.53 | 500 | 477.53 | 96 |
| Тав | 17500 | 10000 | 7500 | 75 |
| Дархан зочид буудал | 150 | 90 | 60 | 67 |
| Фронтиер лэнд групп | 338.44 | 205 | 133.44 | 65 |
| Е-монис | 1954 | 1286 | 668 | 52 |
| Баян-Алдар (Тандэм инвест ББСБ) | 1000 | 700 | 300 | 43 |
| Инвескор ББСБ | 2198 | 1600 | 598 | 37 |
| Баянтээг | 25000 | 18280 | 6720 | 37 |
| Хай би ойл | 70 | 52 | 18 | 35 |
| Хасу-Мандал | 7460 | 5750 | 1710 | 30 |
| Бөөний худалдаа | 500 | 390 | 110 | 28 |
| Ган хэрлэн | 5320 | 4413 | 907 | 21 |
| УБ-БҮК | 458 | 385 | 73 | 19 |
| Хорго хайрхан (Монгол даатгал) | 70 | 60 | 10 | 17 |
| Э-транс ложистикс | 139 | 120 | 19 | 16 |
| Хөдөөгийн тээвэр | 4600 | 4000 | 600 | 15 |

## Ханшийн бууралттай 20 үнэт цаас

| Үнэт цаас | 2019.12.31 | 2018.12.31 | Ханшийн өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | нэгж | % |
| Өндөрхаан | 1390 | 11040 | (9650) | (87) |
| Стандарт агрикалчер групп | 90 | 270 | (180) | (67) |
| Нако түлш | 37 | 109.7 | (72.7) | (66) |
| Стандарт проперти групп | 70 | 170 | (100) | (59) |
| Нийслэл өргөө | 3700 | 8500 | (4800) | (56) |
| Хэрлэн хивс | 45 | 101.2 | (56.2) | (56) |
| Техник импорт | 8000 | 17900 | (9900) | (55) |
| Булган гурил тэжээл | 750 | 1600 | (850) | (53) |
| Адуун чулуун | 1180 | 2100 | (920) | (44) |
| Цагаантолгой | 1625 | 2776 | (1151) | (41) |
| Бөхөг | 1950 | 3300 | (1350) | (41) |
| Дархан хүнс | 2560 | 4300 | (1740) | (40) |
| Дөрвөн-уул | 775 | 1300 | (525) | (40) |
| Лэндмн ББСБ | 42.72 | 71 | (28.28) | (40) |
| Шарын гол | 1134 | 1801 | (667) | (37) |
| Силикат | 68 | 105 | (37) | (35) |
| Айтүүлс | 72.36 | 111.6 | (39.24) | (35) |
| Авто зам | 3400 | 5180 | (1780) | (34) |
| Ногоон хөгжил үндэсний нэгдэл | 90 | 132 | (42) | (32) |
| Тээвэр дархан | 8625 | 12600 | (3975) | (32) |

## Идэвхитэй арилжигдсан 20 үнэт цаас

### Ширхгээр




### Үнийн дүнгээр, ₮



# ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

2019 онд Монголын хөрөнгийн биржийн гишүүнээр 2 үнэт цаасны компани (ҮЦК) шинээр элсч, 2 ҮЦК-ийг гишүүнчлэлээс хассанаар 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар үнэт цаасны зах зээлд Монголын хөрөнгийн биржид гишүүнчлэлтэй 53 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулж байна.

ҮЦК-иудын үнэт цаасны арилжаанд оролцсон байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

| | | **Арилжаанд оролцсон байдал** | | **Үйл ажиллагааны чиглэл** | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ₮ | % | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | "ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК" ХХК | 82,149,325,215 | 28.7% | ■ | | ■ | |
| 2 | "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК | 79,779,218,261 | 27.9% | ■ | ■ | ■ | ■ |
| 3 | "ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК | 19,299,601,318 | 6.7% | ■ | ■ | ■ | |
| 4 | "БИ ДИ СЕК ҮЦК" ХК | 17,613,145,540 | 6.1% | ■ | ■ | ■ | ■ |
| 5 | "АРД СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХХК | 14,851,825,208 | 5.2% | ■ | ■ | ■ | ■ |
| 6 | "АРД КАПИТАЛ ГРУПП ҮЦК" ХХК | 14,648,828,097 | 5.1% | ■ | ■ | ■ | |
| 7 | "МИРЭ ЭССЭТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК" ХХК | 13,593,500,495 | 4.7% | ■ | ■ | ■ | ■ |
| 8 | "БУМБАТ-АЛТАЙ ҮЦК" ХХК | 9,773,026,505 | 3.4% | ■ | ■ | ■ | |
| 9 | "ТЭНГЭР КАПИТАЛ ҮЦК" ХХК | 8,129,251,765 | 2.8% | ■ | | | ■ |
| 10 | "СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК | 4,561,108,855 | 1.6% | ■ | ■ | ■ | ■ |
| 11 | "АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК | 3,813,366,397 | 1.3% | ■ | ■ | ■ | |
| 12 | "ГАҮЛИ ҮЦК" ХХК | 3,615,502,957 | 1.3% | ■ | ■ | ■ | |
| 13 | "НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК | 3,045,785,889 | 1.1% | ■ | ■ | | ■ |
| 14 | "ЛАЙФТАЙМ ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК | 2,689,837,426 | 0.9% | ■ | ■ | ■ | |
| 15 | "ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ҮЦК" ХХК | 1,279,425,184 | 0.4% | ■ | | | |
| 16 | "МАСДАК ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ" ХХК | 629,520,105 | 0.2% | ■ | | | |
| 17 | “ЦЕНТРАЛ СЕКЬЮРИТИЙЗ ҮЦК” ХХК | 603,579,490 | 0.2% | ■ | | | |
| 18 | "ГҮҮДСЕК ҮЦК" ХХК | 559,824,329 | 0.2% | ■ | ■ | ■ | ■ |
| 19 | "БАТС ҮЦК" ХХК | 535,646,915 | 0.2% | ■ | | | |
| 20 | "ЗЭРГЭД ҮЦК" ХХК | 525,334,398 | 0.2% | ■ | ■ | | |
| 21 | "МОНСЕК ҮЦК" ХХК | 480,846,354 | 0.2% | ■ | ■ | | |
| 22 | "ГРАНДДЕВЕЛОПМЕНТ ҮЦК" ХХК | 450,527,122 | 0.2% | ■ | ■ | | |
| 23 | "ЭМ АЙ БИ ЖИ ХХК ҮЦК" | 425,416,500 | 0.1% | ■ | ■ | | |
| 24 | "ДАРХАН БРОКЕР ҮЦК" ХХК | 417,864,798 | 0.1% | ■ | ■ | | |
| 25 | "ДЭЛГЭРХАНГАЙ СЕКЮРИТИЗ ҮЦК" ХХК | 408,198,352 | 0.1% | ■ | ■ | | |
| 26 | "БЛҮМСБЮРИ СЕКЮРИТИЕС ҮЦК" ХХК | 393,034,695 | 0.1% | ■ | ■ | | |

| | | | | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | "ТАВАН БОГД ҮЦК" ХХК | 390,982,716 | 0.1% | ■ | | | |
| 28 | "ХҮННҮ ЭМПАЙР ҮЦК" ХХК | 268,087,664 | 0.1% | ■ | ■ | | |
| 29 | "ӨНДӨРХААН ИНВЕСТ ҮЦК" ХХК | 208,877,986 | 0.1% | ■ | | | |
| 30 | "ГЕНДЕКС ҮЦК" ХХК | 202,493,949 | 0.1% | ■ | ■ | | |
| 31 | "СИКАП ҮЦК" ХХК | 131,659,849 | 0.0% | ■ | ■ | ■ | ■ |
| 32 | "ЭМ АЙ СИ СИ ҮЦК" ХХК | 109,363,404 | 0.0% | ■ | ■ | ■ | |
| 33 | "МЭРГЭН САНАА ҮЦК" ХХК | 105,612,588 | 0.0% | ■ | | | |
| 34 | "КАПИТАЛ МАРКЕТ КОРПОРАЦИ ҮЦК" ХХК | 88,561,105 | 0.0% | ■ | ■ | ■ | |
| 35 | "ЗЭТ ЖИ БИ ҮЦК" ХХК | 79,884,247 | 0.0% | ■ | | | |
| 36 | "БУЛГАН БРОКЕР ҮЦК" ХХК | 79,706,834 | 0.0% | ■ | ■ | | |
| 37 | "НЭЙШНЛ СЕКЮРИТИС ҮЦК" ХХК | 77,791,881 | 0.0% | ■ | ■ | ■ | ■ |
| 38 | "САНАР ҮЦК" ХХК | 70,274,584 | 0.0% | ■ | ■ | | |
| 39 | "АЛТАН ХОРОМСОГ ҮЦК" ХХК | 70,254,555 | 0.0% | ■ | ■ | | |
| 40 | "ДОМИКС СЕК ҮЦК" ХХК | 44,492,168 | 0.0% | ■ | | | |
| 41 | "АРГАЙ БЭСТ ҮЦК" ХХК | 43,456,878 | 0.0% | ■ | ■ | | |
| 42 | "ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК" ХК | 37,738,025 | 0.0% | ■ | ■ | ■ | ■ |
| 43 | "БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХК | 30,501,541 | 0.0% | ■ | | | |
| 44 | "СИЛВЭР ЛАЙТ СЕКЮРИТИЙЗ ҮЦК" ХХК | 24,407,180 | 0.0% | ■ | | | |
| 45 | "АЗИА ПАСИФИК СЕКЬЮРИТИС ҮЦК" ХХК | 22,882,514 | 0.0% | ■ | ■ | | |
| 46 | "ГАЦУУРТ ТРЕЙД ҮЦК" ХХК | 17,805,104 | 0.0% | ■ | ■ | | |
| 47 | "БЛЭКСТОУН ИНТЕРНЭЙШНЛ ҮЦК" ХХК | 13,805,200 | 0.0% | ■ | ■ | | |
| 48 | "ЭФ СИ ИКС ҮЦК" ХХК | 8,829,160 | 0.0% | ■ | ■ | | |
| 49 | "ДИ СИ ЭФ ҮЦК" ХХК | 3,077,824 | 0.0% | ■ | ■ | | |
| 50 | "ЭС ЖИ КАПИТАЛ ҮЦК" ХХК | 278,619 | 0.0% | ■ | ■ | ■ | ■ |
| 51 | "МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК" ХК | - | 0.0% | ■ | ■ | | |
| 52 | "АСЕ ЭНД Т КАПИТАЛ ҮЦК" ХХК | - | 0.0% | ■ | | | ■ |
| 53 | "МОНГОЛ ХУВЬЦАА" ХХК | - | 0.0% | ■ | | | |
| | | **286,403,367,745.36** | **100%** | | | | |

1 Брокер 2 Дилер 3 Андеррайтер 4 Хөрөнгө оруулалтын зөвлөх

*Жич: Гишүүдийг нийт хийсэн арилжааны үнийн дүнгээр жагсаав.*

# ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДИКАТОРУУД

### Зах зээлийн үнэлгээ, их наяд ₮




2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ 2 их наяд 690 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 182.2 тэрбум төгрөгөөр буюу 7.27 хувиар өссөн.

### Нийт зах зээлийн үнэлгээнд I ангиллын үнэт цааснуудын эзлэх хувь & тэрбум ₮

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| APU | ₮675.9 | 36.8% | MANDAL insurance | ₮31.5 | 1.7% |
| ТАВАНТОЛГОЙ ХК | ₮342.3 | 18.6% | ARD ДААТГАЛ | ₮20.0 | 1.1% |
| MIK ХОЛДИНГ ХК | ₮310.6 | 16.9% | ТАЛХ ЧИХЭР ХК | ₮15.6 | 0.8% |
| GOBI MONGOLIAN CASHMERE | ₮210.6 | 11.5% | DN ДАРХАН НЭХИЙ | ₮15.5 | 0.8% |
| МОНГОЛ ШУУДАН | ₮72.2 | 3.9% | sec | ₮14.5 | 0.8% |
| МОНГОЛ улсын УУГАН ҮЙЛДВЭР | ₮72.0 | 3.9% | Bayangol Hotel | ₮11.4 | 0.6% |
| lendmn | ₮34.2 | 1.9% | MAX ИМПЭКС | ₮10.0 | 0.5% |

## ТОП-20 индекс




МХБ-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”-ын дагуу бүртгэлтэй үнэт цааснуудыг зах зээлийн үнэлгээ, өдрийн дундаж арилжаа, арилжаалагдсан өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтээр үнэлж, ТОП-20 индексийн багцыг бүрдүүлдэг.

“ТОП-20" индексийн сагсыг жилд нэг удаа шинэчилдэг бөгөөд 2019 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан “Ард санхүүгийн нэгдэл” ХК, “Хөвсгөл алтан дуулга” ХК, “Ард даатгал” ХК, “АПУ” ХК, “Би Ди Сек” ХК, “Говь” ХК, “ЛэндМн ББСБ” ХК, “Монгол базальт” ХК, “Мик холдинг” ХК, “Мандал даатгал” ХК, “Монгол шуудан” ХК, “Сүү” ХК, “Таван толгой” ХК-иуд хэвээр үлдэж, "Гутал" ХК, "Айтүүлс" ХК, "Хай Би Ойл" ХК, "Женко тур бюро" ХК, "Махимпекс" ХК, "Дархан нэхий" ХК, "Талх чихэр" ХК-иуд хасагдаж шинээр "Улсын их дэлгүүр" ХК, “Ард кредит ББСБ” ХК, “Инвескор ББСБ” ХК, "Монос хүнс" ХК, "Түмэн шувуут" ХК, "Шарын гол” ХК, "Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн" ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТОП 20 индекс 19,621.08 нэгж хүрсэн бөгөөд 2018 оны мөн үетэй харьцуулахад 8.59%-аар буурч 19,621.86 нэгж болсон байна. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21,888.16 нэгж, доод үзүүлэлт 17,922.82 нэгж, дундаж үзүүлэлт 19,978.13 нэгж байсан. Индексийн бууралтад индексийн сагсыг бүрдүүлж буй “ЛэндМн ББСБ” ХК /39,8%/, “Ай түүлс” ХК /35,1%/, “Дархан нэхий” ХК /22,3%/, “Талх чихэр” ХК /21,1%/, “Хөвсгөл алтандуулга” ХК /16,3%/, “Таван толгой” ХК /9,8%/-ийн ханш тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

## MSE A & B индексүүд




2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн MSE A, MSE B индексүүдийг тооцоолж эхэлсэн бөгөөд А индексэд I ангиллын, В индексэд II ангиллын үнэт цааснууд багтдаг.

Тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт 10,268.81 нэгж, доод үзүүлэлт 8,163.84 нэгж, дундаж үзүүлэлт 9,247.29 нэгж байсан бол MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт 8,860.92 нэгж, доод үзүүлэлт 7,335.38 нэгж, дундаж үзүүлэлт 7,984.80 нэгж байсан.

# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ

МХБ нь хөрөнгийн зах зээлд ажиллах мэргэжлийн боловсон хүчний эрэлт, хэрэгцээг хангах, сонирхсон иргэд, оюутан, сурагчдад үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох байнгын болон цаг үеийн асуудлаар сургалт, семинар зохион байгуулах зорилгоор үнэт цаасны зах зээлийн сургалтыг 2005 оноос хойш сар бүр тогтмол зохион байгуулж, сургалтандаа өнөөг хүртэл 5600 гаруй иргэдийг (байгууллага, хамт олны захиалгыг оруулан) хамруулсан байна.

Манай сургалтанд санхүүгийн зах зээлд ажиллаж байгаа мэргэжилтнүүд болон их, дээд сургуулийн дадлага туршлагатай багш нар онол практик хосолсон аргаар хичээл заадаг бөгөөд сургалтанд хамрагдагсад хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголтууд, эрх зүйн зохицуулалт, зах зээлд тавих хяналт, хөрөнгө оруулагчдын эрх үүрэг, зах зээлд оролцогч байгууллагын үйл ажиллагаа, өөрт учрах эрсдлээ хэрхэн бууруулж болох талаар системтэй мэдлэг олж авснаар дотоод, гадаадын аль ч биржийн арилжаанд оролцох чадвартай болж төгсдөг.

2019 онд “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт” болон бусад захиалгат сургалтуудад нийт 150 гаруй иргэд хамрагдсан байна.






**Суралцагчид практик арилжаа хийж буй байдал**



# Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

# Монголын хөрөнгийн бирж ТӨХК

2019 оны 12 дугаар сарын 31



GrantThornton

**"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК**
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

# Хараат бус аудиторын дүгнэлт

**"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**

## *Дүгнэлт*

Бид "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК (цаашид "компани" гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

## *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

## *Онцлох асуудал*

Санхүүгийн тайлангийн Тодруулга 2-д Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой тодорхойгүй байдлыг тайлбарласан байгаад анхаарлаа хандуулна уу. Энэхүү асуудалтай холбоотойгоор бид дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

## *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг

үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн ул итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

GRANT THORNTON AUDIT LLC

**Б.ОСОРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**
Монгол улс, Улаанбаатар хот
2020 оны 3 сарын 31

ayguтны ġapaaн.

Сангийн сайдын 2012 оны
77 тоот тушаалаар 3-р хавсралт батлав.

| Регистрийн дугаар: | 2 | 0 | 7 | 1 | 0 | 9 | 6 |
|---|---|---|---|---|---|---|---|

Хаяг: Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160
Шуудангийн хаяг: info.@mse.mn
Утас: 11313747
Факс: 11325170
Өмчийн хэлбэр: Төрийн 100 хувь, Хувийн ...........хувь

**A**

# "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК -ийн
## 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

| Хянаж хүлээн авсан байгууллагын нэр | Сар, өдөр | Гарын үсэг |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

## Санхүү байдлын тайлан

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК

Тайлант үе: 2019/01/01-2019/12/31

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2019.01.01 | 2019.12.31 |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 830,386,182.81 | 953,430,215.05 |
| 1.1.2 | Дансны авлага | 299,460,784.58 | 49,651,294.32 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | | 367,769.00 |
| 1.1.4 | Бусад авлага | | - |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 1.1.6 | Бараа материал | 26,339,658.92 | 24,567,914.43 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 16,945,120.43 | 8,341,414.98 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 13,160,000.00 | 13,160,000.00 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.20 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,187,291,746.74** | **1,050,518,607.78** |
| 1.2 | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 2,172,002,571.01 | 2,083,731,270.36 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,192,668,889.69 | 653,005,365.40 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | | |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| 1.2.7 | Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.20 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **3,364,671,460.70** | **2,736,736,635.76** |
| 1.3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,551,963,207.43** | **3,787,255,243.54** |
| 2 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| 2.1 | **ӨР ТӨЛБӨР** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 1,052,004,070.07 | 1,541,424,190.07 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 35,974,730.00 | 79,758.38 |
| 2.1.1.3 | Татварын өр | 15,687,380.23 | 13,540,647.75 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 9,406,676.43 | 0.00 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | - |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | | - |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 1,136,000.00 | 9,763,779.67 |
| 2.1.1.9 | Нөөц / өр төлбөр / | | - |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 100,414,116.00 | 40,158,128.65 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд | | |
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,214,622,972.73** | **1,604,966,504.52** |
| 2.1.2 | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.2 | Нөөц / өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | | |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.6 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,214,622,972.73** | **1,604,966,504.52** |
| 2.3 | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Төрийн өмч | 23,130,593,600.00 | 23,130,593,600.00 |
| 2.3.2 | Хувийн өмч | | - |
| 2.3.3 | Хувьцаат өр төлбөр | | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | - |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | - |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 12,362,216.67 | 12,362,216.67 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 446,321,902.02 | 446,321,902.02 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (20,251,937,483.99) | (21,406,988,979.67) |
| 2.3.9.1 | Хуримтлагдсан ашиг/ өмнөх үеийн / | (18,992,094,784.47) | (20,251,937,483.99) |
| 2.3.9.2 | Хуримтлагдсан ашиг /тайлант үеийн / | (1,259,842,699.53) | (1,155,051,495.68) |
| 2.3.20 | **Эздийн өмчийн дүн** | **3,337,340,234.70** | **2,182,288,739.02** |
| 2.4 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **4,551,963,207.43** | **3,787,255,243.54** |

Гүйцэтгэх захирал:...................................................... Х.Алтай

Ерөнхий нягтлан бодогч:................................................ С.Алтаннамар

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020698 2071096
УЛААНБААТАР ХОТ

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

**"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК** Тайлант үе: 2019/01/01-2019/12/31

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2019.01.01 | 2019.12.31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого ( цэвэр )** | **1,660,822,285.77** | **1,474,667,220.37** |
| 2 | Борлуулалтын өртөг | | |
| 3 | **Нийт ашиг ( алдагдал )** | **1,660,822,285.77** | **1,474,667,220.37** |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүгийн орлого | 94,605,834.64 | 69,083,423.93 |
| 6 | Ногдол ашгийн орлого | | - |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | - |
| 8 | Бусад орлого | 37,887,639.20 | 5,441,775.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 2,935,516,451.71 | 2,605,000,415.07 |
| 11 | Санхүүгийн зардал | | - |
| 12 | Бусад зардал | 74,049,265.17 | 60,352,753.15 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз ) | (34,148,908.71) | (33,149,154.37) |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | | 1,150,000.00 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | | |
| 16 | Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз ) | | |
| 17 | Бусад ашиг ( алдагдал ) | | |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )** | **(1,250,398,865.98)** | **(1,148,159,903.29)** |
| 19 | Орлогын татварын зардал | 9,443,833.45 | 6,891,592.39 |
| 20 | **Татварын дараах ашиг ( алдагдал )** | **(1,259,842,699.43)** | **(1,155,051,495.68)** |
| 21 | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )** | | |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )** | **(1,259,842,699.43)** | **(1,155,051,495.68)** |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү | | |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 23.3 | Бусад олз ( гарз ) | | |
| 24 | **Орлогын нийт дүн** | **(1,259,842,699.43)** | **(1,155,051,495.68)** |
| 25 | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг ( алдагдал )** | | |

Гүйцэтгэх захирал:........................................ Х.Алтай

Ерөнхий нягтлан бодогч:........................................ С.Алтаннамар

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК MONGOLIAN STOCK EXCHANGE 9020020699 2071096 УЛААНБААТАР ХОТ